



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 1/59

Хатан суудал

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа “Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж байгуулах” ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга)

С.Болор-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

Б.Адъяасүрэн (Нягтлан бодогч)

А.Гантулга (Байгаль хамгаалагч)

2. Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж байгуулах ажлыг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд орлого авч бүртгэлжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Адъяасүрэн), Нярав (П.Норовсамбуу) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА О.МОНХБАТ

642201039